

Манай улс нээлттэй бодлого явууж ергон хүрээтэй өөрчлөл шинэтгэл хийж биеэ дааж дэгжрэх чиглэл тууштай баримтлаж байгаа өнөөгийн нөхцөлд, ХХ зууны эхээр манай оронд шинэтгэл хийх гэж байсан оролдлогыг судлах нь танин мэдэхүйн ач холбогдолтой төдийгүй түүхэн сургамжтай юм.

Эшлэл, зүүлт

1. 1898 онд Хятадын эрдэмтэн хаан Ювэй болон түүний талынхан хөрөнгөтний шинэтгэлүүд хийхээр оролдлого хийсэн юм.
2. Э.Д.Гримм. Сборник договор и других документов по истории международных отношений на Дальнем Востоке (1842-1923) М., 1927. 148-149.
3. УННС. Дархан ван Пунцагцэрэнгийн гар бичмэл.
4. УТТА. ФМ-9. ХН 3987, 429-430-р нүүр.
5. УТТА. ФМ-9, ХН 3687, 3690, ХН-9.
6. УТТА. ФМ-9, ХН-11.
7. “Страны Востока в политике России в XIX-XX вв. Ир., 1986.
8. С.Идшинноров. XIX-XX зууны зааг дахь Монголын нийгэм эдийн засгийн зарим асуудал. УБ., 1987, 50-р тал
9. Г. Дэлэг. Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ., 1965. 100-р тал.
10. Б.Санжмятав. Гурван улсын хиагтын гэрээний тухай түүхэн үнэн. УБ., 1991
11. Л.Дэндэв. Монголын товч түүх. УБ., 140-р тал.

(1911 ОН) ГАДААД МОНГОЛЫН  
АВТОНОМИЙГ УСТГАСАН НЬ

*Е.А.Белов.*

Энэ асуудал харьцангуй бага судлагдсан. Тухайлбал, Зөвлөлт, монголын түүхчдийн хамтын “БНМАУ-ын түүх” бүтээлд энэ асуудлыг хөндсөн. Уг бүтээл, Монголын феодал, ноёдын “өчүүхэн дээдэс” Октябрийн Социалист хувьсгал Гадаад Монголд нөлөөлөхөөс эмээж, 1919 онд монголын автономит эрхийг устгахыг зөвшөөрсөн<sup>(1)</sup> гэсэн үндсэн дүгнэлтэд хүрсэн байна. Гэвч бүх юм бодит нөхцөл байдал дээр илүү нарийн төвөгтэй байсан юм. Монголын «феодалуудын Октябрийн хувьсгалын нөлөөнөөс эмээсэн айдас Гадаад Монголын автономийг устгахад хүргэсэн гол шалтгаан хараахан биш байв.

Академич Б.Ширэндэв нэгэн бүтээлдээ 1918-1919 оны Монголын түүхэнд, холбогдох<sup>(2)</sup> ОХУ-ын архивын (цаашид ГАРФ, хуучны ЦГАОР) сонирхолтой баримтууд гаргаж тавьсан хэдий ч тэдгээр баримтаа эмх замбараагүй иш татаж авснаас уншигчид Гадаад Монголын автономийг устгахад нөлөөлсөн хүчин зүйлсийн талаар ойлголт авахад төвөгтэй болсон тэр ч бүү хэл чухам ямар хүчин зүйлс гадаад монголын автономийг устгах явдлыг эхлүүлсэн болохыг ойлгохын аргагүй болгожээ.<sup>(3)</sup> Тиймээс урьд хэвлэгдэж байгаагүй оросын архивын баримтанд тулгуурлан дээрх асуудлыг бодитой авч үзэхийг оролдлоо.

Гадаад Монгол нь ард түмнийхээ үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний явцад, өөрийн болоод монголчуудын ашиг сонирхлын үүднээс Хятадад дипломат болон цэргийн даралт шахалт үзүүлж

байсан хаант Оросын идэвхтэй дэмжлэгтэйгээр автономит эрхээ олж авсан билээ. Бээжингийнхэн Гадаад Монголын автономит эрхийг албан ёсоор бататгасан 1915 оны гурван улсын Хиагтын хэлэлцээрт сэтгэл дүүрэн байсан удаагүй. Тэгсэн атлаа Хаант Орос болон Түр засгийн газрын үед Бээжингийнхэн Хиагтын хэлэлцээрийг дахин хянан үзэх, хүчингүй болгох талаар, хүчин чармайлт бараг гаргаж байсангүй.<sup>(4)</sup> Хүчирхэгээ байг гэхэд дор хаяад нэгдмэл Орос орон Хиагтын хэлэлцээрийг чанд сахих баталгаа болж байв.

Октябрийн хувьсгалын дараа Орос орныг ихээхэн туйлдуулсан гурван жилийн иргэний дайн эхэлсэн явдал Хятадын зүгээс Гадаад Монголын талаархи байр сууриа өөрчилж, түүний автономийг устгах бодлогоо хэрэгжүүлэхэд таатай нөхцлийг бүрдүүлсэн юм. Гэхдээ Хятадын засгийн газрын энэ бодлого нь Октябрийн хувьсгалын дараа ч бус, иргэний дайн ид өрнөж байсан 1918 онд ч бус, бүр 1919 оны намар хүрч байж хэрэгжсэн юм. Чухам энэ үед л Гадаад Монгол болон түүний эргэн тойронд Монголын асуудлыг түр зууртаа өөртөө ашигтайгаар шийдэх нөхцөл байдал Хятадын талд бүрдсэн байна.

Хятадын засгийн газар Орос дахь Зөвлөлт засгийг хүлээн зөвшөөрсөнгүй. Автономит Монголын Засгийн газар ч мөн ийм байр суурьнаас хандав. Хятад улс хуучин хаант засгийн элчин төлөөлөгч байсан ван Н.А.Кудашёв тэргүүтэй Оросын төлөөлөгчийн газраар дамжуулан Оростой харилцаж байв. Хүрээнд ч оросын ашиг сонирхолыг хуучин хаант засгийн дипломат агент төлөөлөгч ба Гадаад Монгол дахь ерөнхий консул А.А.Орлов урьдын адил төлөөлж байв.<sup>(5)</sup>

1918 оны 1 сард Эрхүүд, 2 сард Монголтой хил залгаа Троицкосавскт зөвлөлт засаг тогтов. 1918 оны 2 сар хүртэл Маймаачин (Монгол Хиагт) хотыг Монгол, Хятадын тус бүр тавин цэрэг хамгаалж байсныг Хүрээн дэх Хятадын амбан сайд, хошууч генерал Чень И болон монголын засгийн газраас пулемётын хоёр баг цэргээр хүч нэмэгдүүлэв. Тэгэвч Троицкосавскийн большевик Зөвлөлөөс Гадаад Монголын тухайд түрэмгийлэх ямарваа нэг хандлага гаргасангүй. Харин ч Хятадын амбан сайд Чень И-ийн Маймаа дахь туслагч Чжан Цинтун Орос-Хятадын банкны салбар, цахилгаан холбооны станцыг "хамгаалах"-аар Троицкосавскт цэргийн анги оруулсан төдийгүй орон нутгийн зөвлөлөөс эрх мэдлээ хотын Думд шилжүүлэхийг шаардсан нь ёсоор болжээ.<sup>(6)</sup> Гэвч 1918 оны 3 сард Дээд-Үд (одоогийн Улаан-Үд) ээс улаан цэргийн анги ирж Троицкосавскт Зөвлөлт засгийг сэргээсэн тул Хятад цэрэг Маймаачинд буцаж ирэв. Троицкосавскт байсан ахмад В.Юнтер тэргүүтэй цагаан цэргийн анги ч бас энд дутаж иржээ.<sup>(7)</sup> Маймаачинд сууж байсан Оросын Дэд консул В.Лавдовский тэднийг хүлээн авч харуул хамгаалалтын албандаа хүчин зүтгүүлэх болов.<sup>(8)</sup> Үүнд дургүйцсэн Чжан Цинтун Юнтерийн ангийг нэг бол тэндээс зайлуулах, эсвэл зэвсгээ хураалгахыг шаардав. 1918 оны 5 сарын эхээр энэ анги Хиагтаас Хүрээг зорьсон бөгөөд Хужир буланд ирээд урьд Хятадуудын барьсан цэргийн хуаранд байрлажээ. Тэдгээр цагаантнууд А.Орловын дэмжлэгтэйгээр цэргийн сургууль хийхийн сацуу орос, монгол, хятад сайн дурынхныг эгнээндээ элсүүлэн авч орос дахь большевик засагтай хийх аян дайнд бэлтгэх болов.

Цагаантны зэвсэгт отряд Монголын нутаг дэвсгэрт байгаа явдлыг Хятадын амбан сайд Хүрээний засгийн газар аль аль нь таашаахгүй

байв. Учир нь тэд Монгол дахь цагаантуудын үйл ажиллагаанаас болж большевикууд цэрэглэн орж ирж болзошгүй хэмээн болгоомжилж байв. Чень И болон Монголын гадаад явдлын яамны сайд Цэрэндорж нар Орловаас цэргээ Орост нь буцаах удирдамж өгөхийг шаардаж, эс биелүүлбэл Чень И отрядын зэвсгийг өрөө хураах болно хэмээн сүрдүүлэнэ. Орлов бүр 1918 оны 7 сар хүргэж байж тэдэнд Орос уруу гарах, эсвэл монголын нутгийн гүн рүү орж тэндээ цагийг хүлээхийг “зөвлөжээ”. Юнтерийн ангийн нэг хэсэг нь Троицкосавскийн хавьд очиж большевикуудтай тулалдаад аргагүйдэж Монголын нутаг руу буцаж Оросын алт олборлох “Монголор” нийгэмлэгийн нэгэн уурхайд орогнох болов. Нөгөө хэсэг нь Маймаачинаас зайлан явж тэндээс 35 км-т орших Ивцэг өртөөнд очиж суурьшжээ.<sup>(10)</sup>

Хүрээний засгийн газрын зөвшөөрсөнөөр 1918 оны тавдугаар сараас Эрхүү дэх Зөвлөлт засгийн Центрсибирээс явуулсан экспедиц монголоос мал худалдан авч эхлэв. Тус экспедицийг большевик Гейль толгойлж байв. Тэд зундаа 25 мянган бол, 200 мянган хонь худалдаж авчээ. Энэ үед атаман Семёнов Өвөр Байгальд ноёрхолоо тогтоож эхлэв. Тэрбээр 1918 оны есдүгээр сард Гадаад Монголын дорнод хэсэгт цэргийн отряд явуулсан нь большевикуудын худалдаж авсан малыг дээрэмджээ.<sup>(11)</sup> Түүнчлэн Семёновчууд оросын нутагт ч, Монголд ч Хятад худалдаачдыг дээрэмдэж байлаа. Дорнод Сибирт зөвлөлт засаг түр зуур унасны дараагаар большевикууд, улаан цэргүүд, анархистууд харшсанаас зугтан ганц нэгээрээ болон хэсэг бүлгээрээ Монгол руу дайжих болов. Бээжингийн засгийн газар Гадаад Монголын нөхцөл байдал ялангуяа монгол-Оросын хил дээр болж буй үйл явдлыг анхааралтай ажиглаж байв. Хилээр нь гадаад орны иргэд, тэр тусмаа зэвсэгт бүлэглэлүүд дур мэдэн зөвшөөрөлгүй нэвтэрч байхад аль ч засгийн газар дургүйцэх нь ойлгомжтой. Бээжингийн засгийн газар энэ нөхцөл байдлыг ашиглаж Гадаад Монголд цэргээ оруулахаар шийдэв. Гэхдээ үүнийг зөвхөн Монгол Оросын засгийн газрын зөвшөөрөлтэйгээр л хийж чадах байв.<sup>(12)</sup>

1918 оны дөрөвдүгээр сарын эхээр Чень и Гадаад Монголд цэрэг оруулах зөвшөөрлийг Хүрээний засгийн газраас авахаар хөөцөлдөж эхлэв. Үүнийг мэдсэн А.Орлов 4-р сарын 12-нд Чень и болон Цэрэндорж нарт албан захидал илгээж Гадаад Монголд Хятадын цэргийг оруулбал Монголын энэ нутагт зөвхөн харуулын цөөхөн цэрэг байлгахыг Бээжинд зөвшөөрсөн Хиагтын хэлэлцээрийн VII зүйл зорчигдоно гэдгийг анхааруулжээ.<sup>(13)</sup> 4-р сарын 14-нд Чень И-ээс Орювт өгсөн хариундаа: “Аливаа гэрээ энхийн цагт хүчин төгөлдөр үйлчилж байдаг. Харин үймээн самуунтай үет гэрээ нь үйл ажиллагаа явуудах эрх чөлөөг хязгаарлаж болохгүй. Гурван улсын (Хиагтын) гэрээ нь зөвхөн Гадаад Монголын асуудалтай хамаатай бөгөөд харин бидний одоо авах гэж буй арга хэмжээ (цэрэг оруулах) нь гагцхүү гадаад нөхцөл байдлаас үүдсэн тул гэрээгээр хязгаарлагдахгүй”<sup>(14)</sup> гэсэн байна. Дөрөвдүгээр сарын 17-нд Орлов Чень И-д ноот бичиг илгээн Гадаад Монголд хятадын цэргийг оруулах нь Оростой байгуулсан Хиагтын гэрээг зөрчихөд хүргэх болно гэдгийг дахин сануулав.

Хүрээний засгийн газар эхэндээ Хиагтын хэлэлцээрийн VII зүйлийг иш үндэс болгон Чень И-гийн саналыг хүлээн авахаас эрс

татгалзаж байв. Цэрэндорж 1918 оны 5 дугаар сарын 2-нд Орловт явуулсан ноот бичигтээ: Чень И-гийн Гадаад Монголд хятад цэргийг оруулах саналыг Хүрээний засгийн газар хүлээж авах боломжгүй гэж үзэж байгаад Оросын дипломат төлөөлөгч ба ерөнхий консул итгэж болно гээд л сайд цааш нь цэрэг оруулах асуудлыг зөвхөн Хятад, Монгол хоёр тусдаа шийдэх боломжгүй юм". Хэрвээ тэгвэл энэ нь "Гурван этгээдийн гэрээнд харшилсан явдал болно" гэдгийг цохон цаад аргагүйдэж тэмдэглэсэн байна.<sup>(15)</sup>

Гэсэн хэдий ч Чень И Бээжингийн заавраар шаардлагаа шургуу тулгасаар байв.<sup>(16)</sup> Тэр бүү хэл, Бээжин болон Монголын засгийн газарт илгээсэн захидалдаа Гадаад Монголд цэрэг оруулахыг А.Орлов ч дэмжиж байгаа мэтээр бичиж байв. Үнэн хэрэг дээрээ Орлов Хиагтын гэрээг чанд сахихын төлөө тууштай зогсож байв. Харин Үүний оронд Чень И-тэй сөргөлдөх хүчин мөхөс байсан гэвэл өөр хэрэг байлаа. Учир нь тухайн үе бол Орос улсаас А.Орловт ямар ч дэмжлэг үзүүлэх чадваргүй болсон үе байлаа.

Орост тогтсон Зөвлөлт засгийг тэр тусмаа Сибирийн зөвлөлт засгийг А.Орлов хүлээн зөвшөөрөх нь бүү хэл дайсагнаж байв. Цагаантны жаахан ч болов тогтвортой засаглал Орост гарч ирэхгүй л байлаа. Энэ байдлыг ойлгосон Чень И Орловын шаардлагыг эс хайхран монголын засгийн газарт шахалт үзүүлсээр байхын сацуу зарим нэг зүйл дээр мэдэгдэхүйц буулт хийжээ. Тэрбээр 1918 оны 5-р сарын 3-нд хүрээний засгийн газарт хандаж Гадаад Монголын нутагт "одоохондоо нэг батальон цэрэг" оруулах зөвшөөрөл олгохыг хүсчээ. Ингэхдээ тус батальон нь Монголын Оростой нийлсэн хилийг хамгаалах тусгай зориулалттай" болон ямар ч тохиолдолд Гадаад Монголын Засгийн Газрын дотоод хэрэгт оролцохгүй" байж "европын дайн дуусаж, монгол-оросын хил дээр энх тайван байдал тогтмогц"<sup>(17)</sup> монголоос гарна хэмээн тэмдэглэжээ. Хүрээний засгийн газар 5-р сарын 26-нд Хятадын нэг батальоныг Гадаад Монголд оруулахыг зөвшөөрөв. Ийнхүү 8 сар гэхэд их хэмжээний ачаа хөсөг бүхий 500 морин цэрэгтэй батальон монголын газар шороон дээр хөл тавин тэргүүн анги нь 1918 оны 9-р сарын 3-нд Хүрээнд орж ирэв.<sup>(18)</sup> 1918 онд Монголд хятадын цэрэг орж ирэх болсон гол шалтгааныг эхлээд монголын хилийг нэвтрэн Хиагтад ирээд дараа нь Хүрээнд ирж байрласан цагаантны отряд гэж А.Орлов үзэж байв.<sup>(19)</sup> Орловын энэ дүгнэлт үндсэндээ зөв байлаа. Үүн дээр Хятадын цэрэг орж ирсэн явдалд ерөнхий консул өөрөө ч ямар нэгэн хэмжээгээр буруутай хүчин төгөлдөр байсан гэдгийг нэмж хэлэх хэрэгтэй. Учир нь тэрбээр Хятадын амбан сайд, монголын эрх баригчдын эсэргүүцлийг үл тоомсорлон Хужир буланд оросын харьяатууд ба хятад, монголчуудыг элсүүлэн, цэргийн сургууль хийлгэсэн зэрэг цагаантнуудын хууль бус үйл ажиллагааг хэдэн сарын туршид өмгөөлөн хаацалж байв.<sup>(20)</sup> Монголд Хятадын батальон орж ирсний дараа Ивцэг болон Монголорын алтны уурхайн орчим оронгож байсан цагаантнуудын зэвсгийг хятад, Монгол цэргүүд хураан авчээ.

Хүрээний засгийн газар 1918 онд хятадын цэргийг нутагтаа оруулахыг хүсээгүй, юм. Оросын талаас хил үе үе зөрчих болж, цагаантны цэргүүд монголын нутагт байрласан зэргээс шалтгаалан монголын дотоод байдал ээдрээтэй болж ирсэн явдал цэрэг оруулахыг зөвшөөрөхөд хүргэсэн бололтой. Гэвч тун удалгүй олгосон

зөвшөөрлөө өөрчлөх арга саам хийх болсон юм. Миний үзэж байгаагаар үүнийг дараах баримтууд гэрчилж байна.

1918 оны зун Сибирьт зөвлөлт засаг унав. Хүрээний засгийн газар энэ явдлыг түргэн тусгаж Цэрэндорж большевикуудын зүгээс Монголд учруулах аюул нэгэнт арилсан тул цэрэг оруулах зөвшөөрлөө цуцлах болсныг Чень И-д мэдэгдэв.<sup>(21)</sup> Мөн Цэрэндоржоос 8 сарын 20-нд илгээсэн ноот бичигтээ монголын нутаг дахь цэргийнхээ хөдөлгөөнийг цаашид үргэлжлүүлэхийг зогсоохыг шаардав.<sup>(22)</sup> Гэвч дээр тэмдэглэсэнээр Хятадын батальон хойд зүгт аялсаар 9-р сарын 3-нд хүрээнд орж ирсэн юм.

1918 оны намар хятадын цэрэг Хүрээнд орж ирсэнтэй холбогдуулж оросын хэвлэлд Гадаад Монгол автономит эрхээсээ татгалзах бодолтой байгаа мэт мэдээ гарах болов. Эдгээр мэдээнүүд Сибирийн Түр засгийн<sup>(23)</sup> газар болон түүний оронд 1918 оны 11 сард Омскт гарч ирсэн А.В.Колчакийн засгийн газрын анхаарлыг татав.

Сибирийн Түр засгийн газрын гадаад хэрэг эрхлэгч Ю.В.Ключников Гадаад монголын автономийг цаашид хадгалах тухайгаа Хүрээний засгийн газраас Омскийн засгийн газарт хандаж албан ёсны мэдэгдэл гаргуулах талаар хүчин чармайлт тавихыг А.А.Орловоос хүсчээ. Орлов энэ асуудлаар Цэрэндоржтой ярилцахад Хүрээний гадаад хэргийн тэргүүнээс Гадаад Монгол нь Хиагтын гэрээг баримталж, автономит эрхээсээ татгалзахгүй гэдгээ мэдэгдэв.<sup>(24)</sup> Гадаад Монголын автономийг хэвээр хагалах нь Оросын хувьд Алс Дорнодод шийдвэрлэх “онцгой ач холбогдолтой асуудал” гэж Ключников үзэж байв.<sup>(25)</sup> Түүний оронд Колчакийн засгийн газарт Гадаад хэрэг эрхлэх болсон И.И.Сукин Омскийн засгийн газраар дамжуулан Оросын холбоотнууд, тухайлбал АНУ-д хандаж автономит монголыг өөрийн ивээл дор авах хүсэлт гаргахыг хүртэл хүрээний засгийн газарт санал болгож байв.<sup>(26)</sup>

1919 оны эх гэхэд Монгол улс тусгаар тогтнолоо олсон 1911 оны сүүлчээс анхлан дэвшигдсэн Их Монголын үзэл санаа хөдөлгөөн болж өрнөснөөр монголын асуудал онцгой чухал агуулгатай болж ирэв. Богд хаан Живзундамба хутагтын<sup>(26a)</sup> тэргүүлсэн Хүрээний засгийн газар тэр үед халх (ар монгол), баруун монгол, Өвөр монгол, манжуурын барга хошуу, урианхайн хязгаар (тува)-аас бүрдсэн Их монгол улс байгуулах зорилт дэвшүүлж байжээ. Энэ тэмцлийн бодит үр дүн нь 1915 онд Гадаад Монголын олж авсан автономнт эрх болсон юм.

Энэ удаад Өвөрмонголын язгууртан ноёд, лам нар, буриадын зарим сэхээтнүүд, барга монголын ноёд их монголын хөдөлгөөнийг санаачлан өрнүүлжээ. 1918 оны намраас Их монголын хөдөлгөөний үзэл санааг атаман Семёнов ба Өвөр байгаль дахь японы булаан эзлэгчид тэдний Барга, Өвөр, Гадаад Монгол дахь гар хөл бологсод өөрсдийн ашиг сонирхолын үүднээс идэвхтэй сурталчлах болов.

Японы цэргийнхэн Оросын алс дорнодыг мэдэлдээ баттайгаар барьж байхын тулд Өвөр байгаль, Монголын нутгийг хамарсан (Японы талыг баримталсан) “бамбай” улс байгуулж зөвлөлтийн эсрэг томоохон түшиц газар бий болгохыг зорьж байлаа. Мөнгө, зэр зэвсгээр хангадаг япончуудыг түшиглэсэн атаман Семёнов Омск дахь А.В.Колчакийн засгийн газарт 1919 оны зун хүртэл захирагдалгүй Өвөр байгальд ноёрхлоо тогтоож байлаа.

1919 оны хоёр, гуравдугаар сарын заагаар үнэн хэрэгтээ Семёновын удирдлага дор Читад буриад, барга, өвөрмонголын төлөөлөгчид оролцсон их монголчуудын их хурал нээгдэхэд Гадаад Монгол төлөөлөгчдөө ирүүлэхээс татгалзжээ. Уг хурлаас тусгаар тогтносон нэгдсэн Монгол улс байгуулсныг тунхаглая, бор монголын нөлөө бүхий лам Нейс-гэгээн Мэндбаяр тэргүүтэй Түр Засгийн газрыг сонгожээ. Шинэ засгийн газар буриад, өвөрмонгол, баргуудаас бүрдсэн зэвсэгт хүчин байгуулж төмөр замын дагуур өртөөний орчим байрлуулсан байна. Цэргийг үндсэнд нь Семёнов ерөнхийлэн захирч байлаа.

А.В.Колчакийн засгийн газар хийгээд Бээжин дэх Оросын төлөөлөгчийн газар Их Монголын хөдөлгөөнд нэн тааламжгүй хандаж байв. Даруй 3 сарын 7-нд Н.И.Сукин Омскт сууж байсан Англи, Францын албан ёсны төлөөлөгч нарт захидал илгээж “Оросын засгийн газар (Омскийн) Хиагтын гурван этгээдийн гэрээ хэлэлцээрийг сахин мөрдөх болно. Учир иймд “гэрээгээр тогтоосон олон утсын харилцааг зорчиж болох”<sup>(27)</sup>, тул Читийн их хурлыг бүрэн үгүйсгэж байна хэмээжээ. Кудашеваас 1919 оны 3-р сарын 28-нд Сукинд илгээсэн итгэмжилсэн захидалд бичихдээ Их Монголын хөдөлгөөн нь Гадаад Монгол, Баргад Хятад улс цэргээ оруулж нөлөөгөө хүчинтэй болгоход хүргэж болзошгүй юм гэжээ. Түүнчлэн Оросын шууд захиргаан дорх элчин төлөөлөгчөөс “Бамбай” улс болгож хувиргасан Халх, Баргыг буцаж авах гэсэн Хятадын шунахай санаархал хэзээ ч суларч байгаагүйг цохон тэмдэглэсэн байна.<sup>(28)</sup>

Их монголын хөдөлгөөнөөс үүдэж Бээжингийн засгийн газрынхны хүрээнд Гадаад Монголд цэрэг оруулах асуудлыг дахин хэлэлцэж эхэлсэн тухай мэдээ Хятадын хэвлэлд гарлаа.<sup>(29)</sup>

Кудашев 1 сарын 2-нд Гадаад Монголд цэрэг оруулах Хятадын Засгийн газрын санаархлыг эсэргүүцсэн санамж бичгийг Вайцзяобу (Хятадын ГЯЯ)-д явуулжээ. Харин Вайцзяобу “Хятадын газар нутгийн нэг хэсэг учраас Гадаад Монголд “амгалан байдал, дэг журмыг сахиулах асуудалд Хятад амарлингуй хандаж” чадахгүй бөгөөд цэрэг илгээх нь Хятадын засгийн газрын зүгээс “зүй ёсны арга хэмжээ” болно гэсэн хариуг Кудашевт илгээсэн байна. Энэ хариулт Бээжин цэрэг оруулахаа нэгэнт шийдчихсэнийг бэлхнээ нотолж байна.

Хятадын сонинуудад бас Гадаад Монголын автономийг хадгалахын төлөө монголын бүх ноёд адил байр суурь баримтлахгүй байгаа тухай мэдээ гарсан бөгөөд энэ нь ч үнэний хувьтай байлаа.<sup>(32)</sup>

Орловаас Бээжин дэх Кудашевт 1919 оны 1 сарын 12-нд илгээсэн мэдээнд Монголын зарим ноёд автономийг устгах санаатай явдаг тухай яриа аль 1918 оны зунаас түүнд дуулдах болсон хийгээд ерөнхий сайд Сайн ноён хан Намнансүрэнгийн нас барсан 1919 оны 2 сараас энэ яриа улам газар авсан” тухай өгүүлсэн байдаг.

Намнансүрэн “ордны дэргэдэх лам нарын бүлэг”-т хорлогдсон нь хожим тодорхой болсон билээ.<sup>(34)</sup> Энэхүү төр улсын томоохон зүтгэлтэн хүн Автономит Монголын лам нар ба язгууртан ноёдын “нам”-уудын өөр хоорондын байнгын тэмцлийн золиос болсон юм. Ноёд Гадаад Монголд шарын шашны лам нарын нөлөөг сулруулахыг чармайж байлаа. Гэвч Богд хааны дэмжлэг авч байсан лам нарын байр суурь давамгайлж байв. Энэ тэмцэлд Богд хаан Жавзандамба хутагт ба

түүний Да ламын бүлэглэл бүхий л арга мэхийг эрээ цээргүй хэрэглэж байв.

Тэд нар 1912 онд Засагт хан Агваанцэрэн, хараалаад Түшээт хан Дашнямыг хорлосон бөгөөд. 1915 онд гадаад яамны сайд Ханддоржийн хувь тавилан ийн төгссөн билээ.<sup>(35)</sup> Энэ удаа 1919 оны 2 сард засгийн газрын тэргүүний мөн л ингэж хордуулжээ. Эдгээр эрсдэгсэд Монголыг Хятадаас тусгаарлахын төлөө тэмцлийг санаачилж, идэвхийлэн оролцсон гавъяат хүмүүс байв. Намнансүрэн нарын дээд язгууртны нэр нөлөөтэй эмгэнэлт үхэл монгол ноёдын санаа зовоохгүй байхын аргагүй байв. Өөрсдийг нь мөн ийм үхэл хүлээж байж болзошгүйг тэд ойлгож байлаа. Ортовын хэлснээр, ийм байдалд орсон монголын ноёд Гадаад Монгол Хятадын захиргаанд байсан 1912 он хүртэлх үед амь нас аюулгүй, түүгээр ч үл барам Бээжингийн засгийн газраас цалин пүнлүү авч байснаа дурсан санагалзахад хүргэжээ.<sup>(36)</sup>

Тусгаар тогтносон хийгээд Автономит засгийн (1911-1919) үед ноёдын хөрөнгө зорь хомсдсон нь доорхи хэдэн шалтгаантай байв. Энэ үед ноёдын хошуудын албат хамжлага гардаас сүм хийдийн албат шавь болох явдал үлэмж нэмэгджээ. Хамжлага ардыг албат шавь болгох явдлыг Богд хааны зөвшөөрлөөр Шанзавын яамнаас ноёдын ашиг сонирхлыг эс хайхран хэрэгжүүлсний үр дүнд ноёдод татвар төлөх албат ардын тоо хорогдсоор байна. 1919 он болоход албат шавь нар хэдийн Гадаад Монголын хүн амын дөрөвний нэг хувийг эзлэх болсон ажээ.<sup>(37)</sup> Тэд төрд өчүүхэн ч татвар толдоггүй ямар ч алба гүйцэтгэдэггүй байв. Гэтэл цэргийн болон төрийн түшмэдийн албаны зардалд ихээхэн хоронгө шаардагдаж тэр хөрөнгийг ноёдын хошуудаас татварлан гаргуулж байсан нь ноёдын өөрсдийнх нь нуруунд ч тохогдоход хүргэжээ. Тийн атал Шанзавын яам, Богд хаан болон түүний ойрын хүрээний лам нарын зардлын зарим хэсгийг улсын сангаас гаргуулахаар болгосон нь язгууртан ноёдоос дээд лам нарт дургүйцэх шалтаг болов.

Богд хааны урлэгэн зан даанч хязгааргүй байлаа. Түүний зарлигаар хүрээнд мөргөлийн дуганууд бариад зогсохгүй бартаа ихтэй уулархаг тазарт хүртэл сүм барьж байв. Хүрээн дэх ордныхоо модон хаалгыг бариулахад улсын сангаас 150 мянган лан гаргуулсан нь ноёдын дургүйцлийг онцгой хээр төрүүлэв.<sup>(38)</sup>

Эдгээр болон бусад баримтад түшиглэн А.Орлов “Монголын ноёд зарим сайдууд амь нас болон эд хөрөнгийнхөө аюулгүй байдлыг хамгаалахад хятадуудаас өмгөөлөл эрж Гадаад Монголын автономийг халахыг эрмэлзэж байна” гэсэн дүгнэлт хийжээ. Бидэнд энэ дүгнэлтийг үгүйсгэх үндэслэл алга.

(Төгсгөл нь дараагийн дугаарт)

Эшлэл, зүүлт

1. История Монгольской Народной Республики. М., 1983. с.299-300.
2. Ширендыб Б. Монголия на рубеже XIX-XX веков, УБ., 1963, с. 166-169, 176-182
3. Хятадын түүхчид (БНХАУ, Тайван, Гонгконгийн) энэ асуудлаар гоминданы түүхч Чжан Чжунфатай санал нэг байдаг. Тэрбээр, Гадаад Монгол тусгаар тогтнож. дараа нь автономит эрхтэй болоход "оросуудын гар оролцсон" гэж үздэг. Тиймээс Орост иргэний дайн гарсны дараа Монголын ноёд автономийг устгахаар шийджээ. Атаман Семёнов 1918 онд Их Монгол Улсыг байгуулах санааг гаргав. Гадаад Монгол үүнийг дэмжихгүй байсан тул 1919 онд Семёнов Зэвсэгт халдлага хийхээр заналхийлэх болсон. Ийм учраас Хятадын засгийн газар Гадаад Монголд цэрэг оруулж, монгол ноёдын дэмжлэгтэйгээр автономийг устгасан. (Чжан Чжунфа. Дундад иргэн улсын гадаад харилцааны түүх (1911-1921 он). Хятад хэл дээр. Тайбэй., 1961, бүлэг 8, 343-359 т. Гоминданы Хятад болон Тайванд хэд хэдэн удаа хэвлэгдсэн).
4. Гэхдээ Бээжин оросын дотоод байдлыг байнга ажиглаж Гадаад Монголын автономийг устгах тохиромжтой нөхцөл бүрдэхийг хүлээж байлаа. Хятадын цэргийн Аньхой бүлэглэлийн толгойлогч Дуань Цижуй 1917 оны зун Орост болж байсан үйл явдлыг юу гэж үзэж байсан нь сонин юм. Дуань Цижуй жанжин штаб болон цэргийн яаманд доорхи утгатай нууц захидал илгээснийг Бээжин дэх элчин Н.А.Кудашев 1917-6-12-нд Петрградад мэдээлсэн байдаг. "Дотоодын үймээн самуу, бүтэлгүй дайнд бүрмөсөн туйлдсан Орос улс Халхад цаашид анхаарал тавих чадваргүй болов. Хятадын хувьд Гадаад Монголын автономийг устган, энэ нутгийг өөртөө бүрмөсөн нэгтгэх тохиромжтой цаг боллоо" гэжээ. Архив Внешней политики Российской империи, АВПРИ, -Ф. Китайский стол, д. 141, л. 192)
5. 1917 онд Н.А.Кудашев Бээжинд, түүнд захирагдаж байсан Орлов Хүрээнд Түр засгийн газрын дипломат төлөөлөгч байв. Орлов нь Кудашевт захирагдаж байв.
6. 1917-11-7-ноос Сибирийн засгийн газартай харилцаа сэргээх хүртэлх үеийн автономит Гадаад Монголын байдлын талаар А.Орловаас Колчакийн засгийн газрын Гадаад явдлын яамны хэрэг эрхлэгч И.И.Сукинд илгээсэн хувийн захидал. (5 апреля 1919г - ГАРФ, Ф.200, Опиев i, д.480, л.32). Энэ захидал түүхийн маш чухал баримт юм. Түүнд Гадаад Монголын гадаад, дотоод байдлын талаарх А.Орловын үзэл бодлоос гадна хүрээний засгийн газрын ГЯЯ-ны сайд Цэрэндорж, хятад сайд Чень И, зөвлөлт засгийн гадаад хэргийн ардын комиссар Троцкий (Л.Д.Бренштейн). Бээжин дэх оросын элчин төлөөлөгч ван Кудашевын захидал, ноот бичиг, цахилгаан утасыг мөн хавсаргасан байдаг.
7. Мөн тэнд л.33
8. Дорнод Сибирьт Зөвлөлт засаг тогтсоноор Хиагт дахь харуулын морин ангийн Казак цэргүүд хуучин засагт хүчин зүтгэхээс татгалзаж эх орондоо буцсан. Түүнчлэн Хүрээ. Улиастай, Ховдод байсан оросын харуулын морин ангиуд ч өөрсдөө таржээ.
9. ГАРФ, Ф.200, Оп.1, д.480, л.44-45.
10. Мөн тэнд, л.45-46.
11. Мөн тэнд, л.59-60.

12. Хиагтын гэрээний дагуу (VII зүйл) Хятад улс Гадаад Монголд цэрэг оруулахгүй. зөвхөн харуулын анги байлгах (Хүрээнд 150 цэрэг. Хиагт, Улиастай, Ховдод тус бүр 50 цэрэг эрхтэй байв.
13. ГАРФ, Ф.200. Оп i, д.480, л.68-69.
14. Мөн тэнд. л.70.
15. Мөн тэнд, л.71,
16. Чень И ингэж мэдэгдсэн явдал нь дараах, учир шалтгаантай. 1918 оны 3 сард ардын комиссар Троцкий А.Орловыг дипломат төлөөлөгч, ерөнхий консулын албан тушаалаас нь огцруулж, түүний оронд Хиагтад холбоочин байсан Васильевыг томилж байгаа тухай Монголын засгийн газарт мэдэгдсэн. Цэрэндорж Орловтой энэ талаар ярилцаж, монголын засгийн газар Зөвлөлт засгийг хүлээн зөвшөөрөхгүй. Гадаад Хэрэг эрхэлсэн ардын комиссариатаас Монголд дипломат болон консулын төлөөлөгчөө томилохыг дахин оролдвоос өөрийн нутаг дэвсгэрт оруулахгүй гэдэгт найдаж болохыг илэрхийлсэн. Гэвч Орлов большевууд Монголд хүч түрэмгийлэн орж ирж түүнийг баривчлахаас айж байв. Тиймээс ч Чень И-д хандаж большевууд Хүрээнд нэвтэрвэл хамгаалалтандаа авахыг хүссэн. Чень И Орловын мэдэлд “харуулын цэргээ төдийгүй, өөрийн суудаг. өргөөгөө хүртэл” өгөхийг “дуртайяа зөвшөөрсөн”. Чень И дээрх гуилтыг “Монголд цэрэг оруулах үндэслэл” болгож ашигласан гэж хожим нь Орлов Колчакийн засгийн газрын гадаад явдлын яамны хэрэг эрхлэгч И.И.Сукинд бичжээ. (Мөн тэнд, л.37, 76-77).
- 17: Мөн тэнд, л.79-80.
18. Мөн тэнд. л.45.
19. Мөн тэнд, л.33
20. 1918 оны 7 сарын 16-нд Чень и Орловт “Орос офицерууд Монголд ил тодоор цэрэг элсүүлэн, сургууль хийж” харин оросын ерөнхий Консулын газар “зэр зэвсгээр хангаж байна”. Гадаад Монгол, Хятадын газар нутгийн нэг хэсэг тиймээс хэрэв офицерууд бусад намуудын эсрэг тэмцэж байгаа юм бол үүнийгээ Оростоо л хийх хэрэгтэй” гэж бичжээ. Мөн тэнд. л.83).
21. 1918 оны 8 сарын 21-нд Бээжин дэх Оросын төлөөлөгчийн газарт Орловаас илгээсэн нууц цахилгаан утас. АВПРИ, Ф.Миссия в Пекине, д.324, 2.9.
22. Мөн тэнд. л. 18-19.
23. А.Орлов, Н.А.Кудашев нар Сибирийн Түр засгийн газартай 1916 оны 9 сараас харилцаж эхэлсэн нь ГАРФ-ын баримтаар нотлогддог. Орлов, Кудашёв нар нь Сибирийн, дараа нь Колчакийн ЗГ-ын Гадаад Монгол, Хятад дахь дипломат төлөөлөгчийн үүргийг гүйцэтгэж байв.
24. 1918 оны 11 сарын 24-нд Орловоос Ю.В.Ключинковт илгээсэн захидлын хуулбар. Мөн тэнд, л. 12-13.
25. Ю.В.Ключинковаас Бээжинд буй Н.А.Кудашевт илгээсэн нууц цахилгаан утас. 1918 оны 12 сарын 13. Мөн тэнд, л. 20.
26. И.И.Сукинаас Н.А.Кудашёвт 1919 оны 1 сарын 31-нд илгээсэн нууц захидал. Мөн тэнд, л. 29.
- 26а. Гадаад Монголын эзэн хааны бүрэн өргөмжлөл: Шашин төрийг хослон баригч Богд Жибзундамба хутагт хаан.
- 26б. Семёновын их Монголын хөдөлгөөнд оролцсон нь түүний буриад гаралтай холбоотой болов уу.

- 
27. ГАРФ, Ф.200, Оп.1, Д.406, л.3.
  28. Мөн тэнд. л.5. 1919 онь, Их Монголын хөдөлгөөний талаар Е.А.Белов "Авантюра Семёнова (панмонгольское движение в 1919г)-Анналь" Вып.г, М., 1995 номондоо дэлгэрэнгүй бичсэн.
  29. Мөн тэнд, д.476, л. 93.
  30. АВРИ, Ф.Миссия в Пекине, д.324, л. 28.
  31. Мөн тэнд. л. 28.
  32. "Гунянь бао" 1919.2.27 "Миньши бао" 1919.2.27 - Мөн тэнд, 1.30.
  33. Мөн тэнд. л.43-44.
  34. 1919 оны 12 сарын 24-нд Орловаас Сукинд илгээсэн нууц захидлын хуулбар. Мөн тэнд, л. 166.
  35. А. Орлов 1919 оны 4 сарын 12-нд явуулсан мэдээлэлдээ дараах шуугиан дэгдээхүйц баримтыг өгүүлсэн байдаг. Түүний өмнө Монголд дипломат төлөөлөгч, ерөнхий консул байсан А.Я.Миллерд Гадаад Монголд "шашин төрийг зааглаж, засгийн эрхэнд язгууртан дээдсийг гаргахын тулд" төрийн эргэлт хийх хэрэгтэй гэсэн санаа төржээ. (Энэ санаа нь Орост нэлээд элэгтэй байсан Ханддорж хорлогдсоны дараа төрсөн бололтой. Миллер Хүрээ, Улиастай, Ховдод байсан Оросуудын хүчээр 1916 онд төрийн эргэлт хийхээр зэхэж байжээ. Энэ талаарх төлөвлөгөөгөө Оросын ГЯЯ-д явуулсан боловч түүнийг нь зөвшөөрөөгүй аж. (Мөн тэнд, л.324, 1.44).
  36. 1919 -12-24-нд Орловаас Сукинд илгээсэн нууц захидлын хуулбар. Мөн тэнд, л. 167.
  37. 1912-4-12-нд Орловаас Кудашёвт илгээсэн нууц мэдээ. Мөн тэнд. л.43.
  38. 1919-12-24-нд Орловаас Сукинд илгээсэн нууц захидлын хуулбар. Мөн тэнд, 7. 168. 1913 онд 1 лан мөнгө 1.5 рубльтэй тэнцэж байв.
  39. Мөн тэнд, л. 169.